

ХИЧЭЭЛ



Зүгээр л Хоньчин Хүү гэж үү?

ЭВ НЭГДЭЛ Бид бие биенээ хүндэлдэг.

Унших Зүйл

1 Самуел 16:1-13; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 637-642.

Цээжлэх Ишлэл

"Хүн гаднах төрхийг нь хардаг бол Их Эзэн сэтгэлийг нь хардаг". (1 Самуел 16:7).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Хүн бүр Есүсийн хувьд үнэтэй гэдгээ **мэдэх** болно.

Есүсийн хувьд үнэ цэнэтэйгээ **мэдрэх** болно.

Бусдад хүндэтгэл үзүүлэн **хариулах** болно.

Гол Санаа

Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Бурхан Самуелтай ярьж түүнийг Бетлехем рүү явж Иессигийн хүүхдүүдийн нэг нь Израилийн дараагийн хаан болно гэдгийг хэл хэмээн захисан учраас Самуел Бетлехем рүү явж Иессийн 7 хүүг хараад бүгд дараагийн хаан болж чадах юм байна гэж бодсон боловч зөвхөн нэг нь л хаан болно гэж Их Эзэн хэлсэн юм. Самуел Иессигээс өөр хүү байгаа эсэхийг нь асуухад хонио хариулахаар явсан Давидыг байгаа хэмээн хэлэв. Их Эзэн

Самуелд Израилийн дараагийн хаан Давид болно гэж хэлэхэд Самуел ч хэлсэн ёсоор нь Давидыг дараагийн хаанаар өргөмжиллөө.

Энэ бол эв нэгдлийн тухай хичээл

Давид жирийн л нэг хоньчин хүү байсан хэдий ч Самуел түүнд хүндэтгэл үзүүлжээ. Христийн нэгдэл дотор бид хэн нэгнийг нас хүйс, гарал угсаагаар нь ялгаваргүй хүндэтгэж байвал тэр Их Эзэнийг хүндэлж байгаа хэрэг юм. Бид бүгд Их Эзэний хүүхдүүд билээ.

НЭГ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	А. Онцгой Зүйлс Б. Өчүүхэн Зүйлс	жимс, тавиур, хутга жигжиг эд зүйлс, бэлэгний уут
* Залбирал ба Магтаал*	10 минут	13-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	эрэгтэй гутал, хүүхдийн гутал, хайрцаг эсвэл цүнх, Самуелын зураг, жигжиг тосны сав
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>Баталгааны Эргэлт</i>	малгай
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Хонио Хуваалцах нь</i>	хонины загвар (х. 140), хатуу цаас, өнгийн харандаа, цавуу, даавуун бөмбөг

Багшийн Баяжуулалт

"Гаднах гоо үзэсгэлэн нь Их Эзэний хувьд тэргүүлэх зүйл биш юм. Зан аашны илэрхийлэл болон зан авир дээр гарч байгаа хүний мэргэн ухаан болон сайн чанар нь хүн төрөлхтний жинхэнэ үнэн, дотоод үнэ цэнэ, зүрх сэтгэлийн сайн чанар бөгөөд эдгээр нь Их Эзэнд хэрхэн хүлээн зөвшөөрөгдөхийг тодорхойлдог. Бид Самуелын алдаанаас суралцаж болох бөгөөд нэр хүнд болон царай зүсний үзэсгэлэнтэй байдлын тухай ойлгож болно. (Эцэг Өвгөд бас Зөнчид х. 638)

"Хүн өөрийн хязгаарлагдмал шүүмжлэлдээ баригдаж байдаг. Их

Эзэн модноос хэрхэн үр жимс гарахыг л харах хүсэлтэй. (Сүмийн гэрчлэл 8-р боть, х. 183)

Хүмүүсийг үнэлэхдээ та ямар шалгуур хэрэглэдэг вэ? Та Шаббат хичээлд ирсэн сурагчдыг Есүс тэднийг хэрхэн үнэлдэг шиг үнэлж чаддаг уу?

Өрөөний Зохион Байгуулалт

Мод, бут, цэцэг гэх мэтийг өрөөгөө чимэглэхдээ ашиглах ба том ногоон даавуу эсвэл цаасыг ногоон зүлэг мэт харагдуулахаар газар дэвс. Мөн том цэнхэр даавуу эсвэл цаасыг гол болгон ашигла. Зүлэг болгосон хэсэг дээрээ тоглоомон хонь тавина.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Онцгой Зүйлс

Хэрэгтэй зүйлс:

- жимс
- тавиур
- хутга

Төрөл бүрийн жимс тавиурт тавин харуулаад "Энэ ямар жимс вэ? Дуртай юу? (жимсийг нэг нэгээр нь харуулах) Чиний хамгийн дуртай жимс аль нь вэ?" хэмээн асуугаад жимсний тухай ялангуяа тэдгээрийн амт, үнэр, ялгаа, жимс нэгэн бяцхан үрнээс хэрхэн ийм том болсон тухай ярилц. Гадна талдаа тийм ч сайхан харагддаггүй жимс эсвэл кивиг харуулаад түүнийгээ зүсэж хүүхдүүдээр амсуулж үз. Гаднаа тийм ч гоё харагдахгүй байсан жимс дотроо ямар сайхан амттай байгааг нь ярилцаарай.

Багатгах нь

Асуух: Чиний хамгийн дуртай жимс юу вэ? Бүхий л жимснүүд бидэнд сайн уу? Жимс нь бидний биед тустай учраас бид түүнийг идэх хэрэгтэй. Бүх жимс тун чухал юм. Зарим жимс гаднаасаа тийм ч амттай харагдахгүй боловч амсаад үзэхэд ямар амттай байдаг гээч.

Энэ нь бусад хүмүүсийн хувьд адил. Бид бүгд бие биенээсээ ялгаатай боловч гаднах төрхөөр нь тухайн хүнийг тодорхойлоход хэцүү байдаг. Бид тэр хүнийг мэдэх шаардлагатай болдог. Их Эзэн хүмүүсийн зүрх сэтгэлийг хардаг. Эзэн Бурхан хүмүүсийн дотор сэтгэл ямар байгааг нэгд нэггүй мэддэг бөгөөд Тэр бидэнд маш их хайртай. Их Эзэн хүмүүсийг чухалд үзэж байхад бид бие биедээ хэрхэн хандах хэрэгтэй вэ? Тиймээ, бид хайрыг л үзүүлэх хэрэгтэй. Хүмүүс Есүсийн хувьд чухалд тооцогдсон болохоор бид ч мөн бие биенийгээ чухалд тооцон хандах хэрэгтэй. Өнөөдрийн гол санаа:



Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Намайг дагаад хэлээрэй.

Хэрэгтэй зүйлс:

- жижиг зүйл
- бэлэгний хайрцаг

Б. Өчүүхэн Зүйлс

Янз бүрийн хэмжээтэй бэлэгний хайрцаганд хос сүлбээр зүү, түлхүүр, жижиг соронз, шүдэнз, үр гэх мэт тун чухал зүйл хий. Асуух нь: Энэ хайрцаган дотор юу байгааг та нар тааж чадах уу? Энэ хайрцаган дотор ямар нэгэн том зүйл байгаа гэж бодож байна уу эсвэл жижиг зүйл үү? Энэ дотор чухал зүйл байгаа юу эсвэл тийм ч чухал зүйл биш үү?

Хүүхдүүдээр хайрцаг бүрийг нэг нэгээр нь нээлгээд дотор нь байгаа зүйлийн тухай ярилцаарай. Асуух нь: **Энэ зүйлийг бид юунд ашигладаг вэ? Энэ яагаад тийм чухал гэж?**

Бататгах нь

Асуух нь: **Ямар нэгэн зүйл нь чухал бас үнэ цэнэтэй байхын тулд заавал том хэмжээтэй байх ёстой гэж үү? Хүмүүс ч мөн Есүсийн хувьд чухал байхын тулд том болж өсөх хэрэгтэй гэж үү? Та нар жижигхэн ч Есүст огтхон ч хамаагүй юм. Есүс чамайг яг байгаагаар чинь л хайрладаг.**


Есүст хайртай хүмүүс бусдыг үнэ цэнэтэй чухал гэж боддог учраас тэдэнд хүндэтгэл үзүүлэн харьцдаг шүү дээ. Хэн нэгэнд хүндэтгэл үзүүлнэ гэдэг маань юу гэсэн үг вэ? Энэ нь тухайн хүнд найрсаг хандахыг, түүнийг хүлээн авах, түүнтэй ямар нэгэн юмаа хуваалцах, түүнд сайхнаар хандахыг болон Есүс тэднийг хайрладаг шиг тухайн хүнийг хайрлахыг хэлж байгаа юм. Өнөөдрийн бидний гол санаа бол:



Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Намайг дагаад хэлээрэй.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нохорлол

Хэрэв зохимжтой гэж үзвэл хүүхдүүдийн орохдоо танд хэлсэн, тэдэнд таалагдсан эсвэл таалагдаагүй зүйлүүдийн тухай бусдад нь дуулгаарай. Өнгөрсөн долоо хоногт сурсан мэдсэн зүйлсээ болон цээжилсэн ишлэлээ сэргээн давтах цаг гаргаарай. Төрсөн өдөр, тэмдэглэлт үйл явдал болон амжилт бүтээлийг тэмдэглэхээ мартуузай. Ирсэн зочиддоо онцгойлон талархаарай.

Санал болгох дуунууд

- "Сайхан зүйл" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 261*)
- "Сайныг үйлдэцгээе" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 263*)
- "Хуваалцах" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 278*)
- "Миний хийж чадах зүйлүүд" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 299*)

Зорилго

Энэ улирлын хандив зориулагдаж байгаа газар анхаарлаа хандуулна уу. Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс түүх ашиглаарай.

Хандив

Хэлэх: **Бид Шаббат хичээлд хандив өргөлөө авчирснаараа бусдад хайртайгаа илэрхийлж чадах боломжтой.**

Залбирал

Ээлж ээлжээрээ залбиран, найз болон гэр бүлийн хэн нэгэн гишүүн болон хүүхдүүдийн хувьд онцгой нэгний төлөө Их Эзэнд талархаарай.

*Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- эрэгтэй хүний найман өөр гутал
- хүүхдийн нэг хос гутал
- хайрцаг эсвэл цүнх
- Самуелын зураг
- тосны жижиг сав

Хэлэх нь: Би та нарт нэгэн түүх ярьж өгье. Гэхдээ надад та нарын туслалцаа хэрэгтэй. Би та нарт энэ зургийг үзүүлэх үед (Самуелын зураг) та нар "Самуел" хэмээн хэлээрэй. Би үүнийг хэлэхгүй. Энэ түүхийг ярихад надад туслан та нар нэрийг нь хэлэх хэрэгтэй. Одоо бүгдээрээ давтаж үзье. (Зургийг үзүүлэн хүүхдүүдээр "Самуел" хэмээн хэлүүл).

Түүхийг уншиж эсвэл ярьж өг.

Нэгэн өглөө Их Эзэн өөрийн туслагч **Самуелд** [Зургийг үзүүлж хүүхдүүдээр "Самуел" хэмээн хэлүүл] **"Самуел** ээ [зургийг үзүүлэх] Надад чамаар хийлгэх нэгэн онцгой ажил байна. Чи Бетлехем рүү явж Иессиг олж уулзаарай. Би Иессигийн хүүхдүүдийн нэгийг нь дараагийн хаан болгоно. Тосоор дүүргэсэн сав аваад яв" гэжээ.

Тэгээд **Самуел** [зургийг үзүүлэх] Их Эзэний хэлсэн ёсоор саваа тосоор дүүргэн Бетлехем рүү явлаа. Яагаад тэрээр савтай тос авч явсан учрыг та нар мэдэх үү? Учир нь Их Эзэний сонгосон Иессигийн хөвгүүдийн нэгийг **Самуел** [зургийг үзүүлэх] тэрхүү тосоо толгой дээр нь асгаж түүнийг тослох ёстой юм. Энэ нь түүнийг Их Эзэний сонгосон хүн гэдгийн бэлэг тэмдэг болдог байна.

Самуел [зургийг үзүүлэх] тоос бужигнасан замаар уруудан алхалж байхдаа Их Эзэн түүнд яг хэнийг сонгосноо хэлээгүй учир бага зэрэг санаа зовж байлаа. Тэр хэнийг тослохоо хэрхэн мэдэх бол? Тэгээд тэрээр "Их Эзэн надтай ярьж үүнийг хийлгэхийг хүсэж байгаа учир хэнийг тослохыг минь лавтай хэлж өгнө" хэмээн боджээ.

Самуел [зургийг үзүүлэх]

Бетлехемд ирээд тосгоны удирдагч нартай уулзахдаа Иесси болон түүний хөвгүүдийг ч урив.

Самуел [зургийг үзүүлэх]

хөвгүүдийг харан инээмсэглэнэ. Иессигийн нэг хүү ихэд өндөр бас маш царайлаг нэгэн байхыг хараад [хайрцагнаас хамгийн сайн нэгэн гутлыг гаргах] "Энэ лав Их Эзэний сонгосон дараагийн хаан мөн байх" хэмээн дотроо боджээ.

Иесси **Самуелд** [зургийг үзүүлэх] тэр хөвгүүнийг танилцуулахад хүү яг л ханхүү шиг харагдав. Тэр хүү Израилийн дараагийн хаан болох уу? Үгүй ээ.

Их Эзэн **Самуелд** [зургийг үзүүлэх] "Царайлаг нэгнийг бүү харагтун, мөн өндөр нуруутай нэгнийг ч бүү харагтун. Учир нь тэр миний сонгосон хүн биш" хэмээв.

Тэгээд Их Эзэн **Самуелд** [зургийг үзүүлэх] нэгэн онцгой зүйлийг шивнэлээ. "Их Эзэн хүмүүсийн нүдээр хардаггүй. Хүмүүс гадна төрхийг нь хардаг бол Их Эзэн зүрх сэтгэлийг нь хардаг юм". Энэ өгүүлбэрийг надтай хамт давтан хэлээрэй. [Энэхүү ишлэлийг хамтдаа давтан хэлэх].

Дараа нь Иесси **Самуелд** [зургийг үзүүлэх] өөр нэгэн хөвгүүнээ танилцуулахад тэрээр ихэд ажилсаг харагдлаа. [Өөр нэгэн гутлыг савнаас гарган харуулах] Гэвч Их Эзэн түүнд "Тэр мөн л миний хайж буй хүн биш байна" гэв.

Иессигийн гурав дахь хөвгүүнийг **Самуелд** [Самуелын зургийг харуулахад бас нэгэн спорт гутлыг гаргах] танилцуулахад тэр хүү ихэд том сайхан биетэй хүчтэй харагдлаа. Би мэдэхгүй ээ, тэр хүү ямар нэгэн зүйл хийхдээ сайн л байх. Гэвч тэр мөн л Их Эзэний сонгосон хүн биш байсан.

Самуел [зургийг үзүүлэх] Иессигийн долоон хөвгүүдтэй бүгдтэй нь

танилцаад [өөр 4 хос гутлыг гаргах] өөрөө өөртөө эргэлзэж эхлэв. Тэр үед Их Эзэн **Самуелыг** дуудаад [зургийг үзүүлэх] Иессигийн хөвгүүдийн нэгийг сонгосон гэдгээ дахиад л хэллээ. Гэвч **Самуелын** танилцсан [зургийг үзүүлэх] Иессигийн хөвгүүдийн нэг нь ч биш байв. Гэхдээ хүлээгээрэй. **Самуел** [зургийг үзүүлэх] Иесси дээр эргэн очиж "Танд өөр хөвгүүн бий юу?" гэж асуухад Иесси "Бас нэг хүү бий, тэр хамгийн отгон нь бөгөөд хөдөө хонио хариулж байгаа" гэжээ.

"Түүнийг явж авч ирэгтүн. Тэр хүүг ирэн иртэл бид зоог барихгүй" гэж **Самуел** [зургийг үзүүлэх] хэлэв.

Тэгэхэд Иесси Давидыг авчруулахаар хүн илгээлээ.

Давид ч ирлээ [Хүүхдийн нэг хос гутлыг гаргах]. Тэрээр хөөрхөн бөгөөд Их Эзэнд талархлын дуу дуулах дуртай, Их Эзэнд хайртай бөгөөд Их Эзэн ч түүнд ихэд хайртай юм. Тэр үед хоньчин хөвгүүд тийм чухал хүмүүсийн тоонд ордоггүй байлаа. Гэвч Их Эзэн **Самуелд** [зургийг үзүүлэх] "Тэр хүү бол миний сонгосон хүү мөн билээ, түүнийг сонгон тослогтун, тэр дараагийн хаан болох болно" гэж айлдав.

Тэгээд **Самуел** [зургийг үзүүлэх] савтай тосыг авч [Савтай тосыг харуулах] Давидын толгойг тослоход хэдийгээр тэр жаахан хоньчин хүү байсан хэдий ч Их Эзэн Давидтай хамт байж тэр өдрөөс эхлэн түүнийг адислан ивээж эхэлжээ.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах хугацаа өгөөрэй: **Их Эзэн яагаад Давидыг сонгосныг мэдэх үү? Яагаад Их Эзэн Давидын ах нараас сонгоогүй вэ?**

Есүс хүүхдүүдийг ч мөн онцгой нэгэн ажилд дуудна гэж та нар бодож байна уу? Их Эзэний хувьд хүүхдүүд чухалд тооцогдсон өөр ямар нэгэн Библийн түүхийг та нар мэдэх үү? (Самуел, Иоаш, Есүс дээр ирсэн хүүхдүүд, Бяцхан Мосе).

Есүс хүн бүрт хайртай. Есүст

хайртай хүмүүс хүн бүрийг чухал, үнэ цэнэтэй гэдгийг мэддэг учраас тэдэнд үргэлж хүндэтгэл үзүүлдэг юм. Гол санаагаа хамтдаа хэлье:



Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Библи Судлал

Библиэ нээгээд 1 Самуел 16:1-13-г гаргаад **"Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээрэй. Тэгээд ишлэлээ чангаар уншаарай.

Хэрэгтэй зүйлс:

Библи

Бататгах нь

Асуух нь: **Самуел хэнийг хаан болно гэж бодсон бэ? Хаан болох хөвгүүн Давид байсан гэдгийг мэдээд Самуел яасан бэ?**

Давид хэдэн ахтай байсан бэ? Тэрээр хамгийн отгон нь байсан уу? Эсвэл хамгийн ууган нь байсан уу? Самуел Давидыг дуудуулах үед тэр юу хийж байсан бэ? Тэр хийж байсан зүйл нь тийм чухал байсан уу?

Давидыг Их Эзэний сонгосон хүн гэдгийг Самуел хэрхэн харуулсан бэ? Ирээдүйд Давидыг ямар онцгой ажил хүлээж байсан бэ? Давид Их Эзэнд хайртай байсан уу?

Цээжлэх Ишлэл

1 Самуел 16:7-г гаргаад **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гээд ишлэлийг чангаар уншаарай. **"Хүн гаднах төрхийг нь хардаг бол Их Эзэн зүрх сэтгэлийг нь хардаг."**

Хэрэгтэй зүйлс:

Библи

Асуух нь: **Энэ өгүүлбэр ямар утгатай вэ? Хүмүүс бусдын хийж, ярьж байгааг мөн гаднах үзэмжийг нь хардаг. Гэвч Есүс хүмүүсийн тухай хэний ч мэдэхгүйг мэддэг юм. Тэрээр хүний дотоод зүрх сэтгэл дэх сайн мууг сайн мэддэг шүү дээ.**

Тэгээд дараах зааврын дагуу цээжлэх ишлэлээ тайлбарлан заагаарай.




Хүмүүс

Алгаа доош харуулаад гараараа тойрог үүсгэн зурах.



гаднах төрхийг нь

Алгаа доош нь харуулан цээжнээсээ урагш доош нь буулгах.



хардаг бол

Гараараа саравчлаад хоёр тийшээ харах.



Их Эзэн


Дээшээ заах.



зүрх

сэтгэлийг нь

Зүрх рүүгээ заах.



хардаг юм.

Гараараа саравчлаад хоёр тийш харах.



1 Самуел 16:7

Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

3

Хичээлээ Заах

Талархлын Тойрог

Хэрэгтэй зүйлс:

малгай

Хүүхдүүдтэйгээ хамт тойрон суугаад нэг хүүхдэд малгайг өгөөд өмсүүл. Тэгээд малгай өмссөн хүүхдийн тухай сэтгэгдлийг бусдаас нь сонс.

("Тэр надтай тоглоомоо

хуваалцдаг", "Тэр бусдад тусалдаг" гэх мэт).

Хүүхэд бүр тэр хүүхдийн тухай сэтгэгдлээ хэлж дууссаны дараа өөр нэгэн хүүхдэд малгайг өмсүүлж түүний тухай бусдаас нь сонс. Тойргийг дуустал үргэлжлүүлээрэй. (Олон хүүхэдтэй ангид хүүхдүүдийг бүлэг болгон суулгаад бүлэг тус бүрт нэг том хүнийг туслуулахаар суулгаарай.)

Бататгах нь

Асуух: **Бусдын талаар сайн зүйл ярихад та нарт ямар байдаг вэ? Чиний тухай сайн зүйл хүмүүс ярихад чамд**

ямар байдаг вэ? Бусдын сайныг ярих нь Их Эзэнд тэдгээр хүмүүс чухал гэдгийг харуулж чадаж байна уу? Бусад хүмүүс өөрсдийгөө онцгой нэгэн гэдгийг мэдэхэд энэ нь тус болох болов уу?

Есүст хайртай хүмүүс бусад хүмүүсийг чухал гэдгийг мэддэг. Хэн нэгэн бүдүүн, туранхай, том, жижиг байх нь огтхон ч хамаагүй бөгөөд Есүсийн хувьд бүхий л хүмүүс чухал юм. Мөн Есүст хайртай хүмүүс бусдыг хүндэлж чаддаг. Чи бусдад хэрхэн хүндэтгэл үзүүлж чадах вэ? Гол санаагаа санацгаая:



Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Намайг дагаад хэлээрэй.

4

Хичээлээ Хуваалцах нь

Хонио Хуваалцъя

Юуны өмнө, хүүхэд бүрт зориулан хатуу цаасан дээр хонины загвар зургийг (140-р хуудас хар) хувиран зөөлөн хөвөн бөмбөлөгөөр зурсан хонины бие хэсэг дээр наалгаж мөн хонины хажууд шилбүүр барин зогсож буй Давидыг зуруул.

Бататгах нь

Асуух: Самуел Давидыг тосоор тосолж түүнд өөрийг нь дараагийн хаан болох болно гэж хэлэхэд Давидад ямар байсан гэж та нар бодож байна вэ?

Хэн нэгэн чамд зориулж ямар нэгэн сайхан зүйл хийхэд чамд ямар байдаг вэ? Мөн чи бусдын төлөө ямар нэгэн сайн зүйл үйлдэхэд чамд ямар байдаг вэ?

Биднийг бусдад зориулан ямар нэгэн сайныг үйлдэх үед тэр нь тухайн хүн ямар онцгой болохыг нь мэдрүүлж чаддаг юм. Есүст хайртай хүмүүс бусдад сайхан ханддаг. Энэ нь ч мөн бусад хүмүүсийг баяртай болгодог юм.

Энэ долоо хоногт та нар хэн нэгэнд Давидын тухай ярьж өгч байхдаа энэхүү хонио түүнтэй хуваалцаарай. Энэ бусад хүмүүс чиний хувьд ямар чухал вэ гэдгийг мэдрүүлж чадна.

Өнөөдрийн бидний гол санаа:



Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Намайг дагаад хэлээрэй.

Хэрэгтэй зүйлс:

- хонины загвар (140-р хуудас)
- хатуу цаас
- өнгийн харандаа
- цавуу
- хөвөн

Хичээлийн Хаалт

Есүсийн хувьд хүн бүр чухал гэдгийг хүүхдүүд санаж байхын төлөө, мөн энэ долоо хоногт хүүхдүүд хүмүүст хайртай гэдгээ харуулах ямар нэгэн арга замыг олоосой хэмээн залбирна.

ТЭМДЭГЛЭЛ: Сүмийнхээ самбар дээр хийх гэж байгаа үйл ажиллагаандаа зориулан хуучин бээлий авчрах тухай зарлал тавиарай. Энэ нь 5-р хичээл дээрх түүхээ хуваалцах хэсэгт хэрэг болно.

Зүгээр л Хоньчин Хүү гэж үү?

Унших Зүйл

1 Самуел 16:1-13; Эцэг Өвгөд ба Зөнчид 637-642.

Цээжлэх Ишлэл

"Хүн гаднах төрхийг нь хардаг бол Их Эзэн зүрх сэтгэлийг нь хардаг" (1 Самуел 16:7).

Гол Санаа

Их Эзэний хүмүүс хүн бүрийг үнэтэй чухал гэдгийг ойлгох болно.

Та Есүсийн хувьд чухал нэгэн үү? Бас таны аав ээж, найз нөхөд тань мөн чухал уу? Их Эзэний хувьд хүн бүр чухал юм. Давид хэмээх жаахан хоньчин хүү ч мөн чухал юм.

Нэгэн өглөө Их Эзэн өөрийн зөнч Самуелтай ярьж түүнд "Бетлехем рүү явж, тэнд амьдардаг Иесси гэдэг хүнийг ологтун. Би Иессигийн нэгэн хөвгүүнийг Израилийн дараагийн хаан болгохоор сонгон авлаа.

Тосоор дүүргэсэн савыг мөн өөртөө авч явагтун" хэмээв.

Самуел саваа тосоор дүүргэн дараагийн хаан болох Иессигийн хөвгүүнийг олж тослохоор аян замдаа гарлаа.

Самуел Бетлехемд ирээд Иесситэй уулзав. Тэгээд тэрээр Их Эзэнд өргөл өргөхөөр бэлтгэж тэр үйл явдалдаа тосгоны удирдагчид болон Иессиг хөвгүүдийнх нь хамт дууджээ.

Иесси долоон хөвгүүнтэйгээ хамт ирэв. Самуел тэдэн лүү инээмсэглэн харахад, ууган хүү Элиаб нь ихэд царайлаг бөгөөд өндөр харагджээ. "Энэ хүү л дараагийн хаан ширээ залгамжлах хүү мөн байх" хэмээн Самуел бодсон боловч Их Эзэн түүнд "Царайлаг болон өндөр нэгнийг бүү харагтун, учир нь тэр миний сонгосон хүн биш юм" гэв. Тэгээд Их Эзэн Самуелд нэгэн онцгой зүйлийг хэллээ. "Их Эзэн хүмүүсийн нүдээр хардаггүй юм. Хүмүүс зөвхөн гаднах төрхийг нь хардаг бол Их Эзэн зүрх сэтгэлийг

нь хардаг юм" гэв.

Иесси Самуелд дараагийн хүүгээ танилцуулахад тэр нь мөн л Их Эзэний сонгосон нэгэн биш байлаа.

Иесси Самуелд хөвгүүдээ нэг нэгээр нь танилцуулахад тэдгээрийн нэг нь ч Их Эзэний сонгосон нэгэн биш байв. Самуел сүүлдээ эргэлзэн, Иессигээс "Танд өөр хүү байгаа юу?" гэж асуухад Иесси "Нэг бий, тэр миний хамгийн отгон хүү бөгөөд хөдөө хонио хариулж байгаа" гэлээ. Тэр үед хоньчин хөвгүүд тийм ч чухалд тооцогддоггүй байв.

"Түүнийг авчир, тэр хүүг иртэл бид зоог барихгүй" гэж Самуел хэлэхэд удалгүй Давид ирлээ. Давид Их Эзэнд хайртай бөгөөд хэдийгээр тэр жирийн л нэг хоньчин хүү ч гэсэн Их Эзэн түүнд ихэд хайртай байв.

"Миний сонгосон хүн энэ мөн байна, түүнийг тослогтун" гэж Их Эзэн Самуелд хэллээ.

Самуел хүүг тослоход Их Эзэний Ариун Сүнс түүнийг адислан түүнд гайхамшигт ажлыг хийх хүч чадал өгчээ. Хоньчин хүү Давид Их Эзэний хувьд чухал нэгэн байсан уу? Тиймээ, тэр үнэхээр чухал нэгэн байсан бөгөөд та ч бас Их Эзэний хувьд хамгийн чухал хүн мөн билээ.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

- Хүмүүс**.....Алгаа доош харуулаад гараараа тойрог зурах.
- гаднах төрхийг**Алгаа доош харуулаад цээжнээсээ доош буулгах.
- хардаг бол**Гараараа саравчлаад хоёр тийшээ харах.
- Их Эзэн**.....Дээшээ заах.
- зүрх сэтгэлийг нь**.....Зүрх рүүгээ заах.
- хардаг юм.**Гараараа саравчлаад хоёр тийшээ харах.
- 1 Самуел 16:7**Алгаа нийлүүлээд дэлгэнэ.



Ням

1 Самуел 16:1-13-г уншаад "Самуел яагаад Давидын ах нарын нэгийг дараагийн хаан болохоор сонгогдсон гэж бодсон бэ? Их Эзэн яагаад Давидыг сонгосон бэ?" гэж асуу. Давидын тухай хэн нэгэнд хэлж байхдаа түүнд хонио өгөхөд нь та хүүхдэдээ туслаарай. (Эсвэл хүүхдээрээ хонь зуруулан түүн дээр нь хөвөн наалгасан ч болно.)


Даваа

Хүүхэдтэйгээ хамтаар гэр дотор байгаа жижиг хэдий ч чухал зүйлүүдийг олоорой. Хүүхдүүд Их Эзэний хувьд ямар их чухал вэ гэдгийг хүүхэд тань ойлгохын төлөө Есүсээс залбиран гуйгаарай.

Мягмар

Жижиг чулуу, навч, үр, өд гэх мэт байгалд байдаг зүйлсүүдийг хүүхэдтэйгээ хамт олоод тэр олсон зүйл тань ямар чухал болохыг хамтдаа ярилцаарай.

Мөн өөрийн улсад байдаг хамгийн чухал хүний зургийг үзүүлээд тэр хүн яагаад чухал болохыг ярилцаад асуух нь: Энэ хүн чамаас ч илүүтэйгээр Их Эзэний хувьд чухалд тооцогдох уу? Бүр эмээгээс чинь илүү гэж үү? Яагаад?



Лхагва

Найзууд эсвэл гэр бүлдээ байгаа бусад хүүхдүүдийн тоог хүүхдээрээ гаргуул. Асуух нь: Давид хэдэн ахтай байсан бэ? Давид хамгийн ууган нь байсан уу? Хамгийн отгон нь байсан уу? Эсвэл дундах нь байсан уу? Чи айлын хэд дэх хүүхэд вэ?

Пүрэв

Гэр бүлийнхнийхээ хамгийн дуртай хоолыг бэлдэхдээ хүүхдээрээ туслуулаарай. Хүүхдээрээ хоолоо зөөлгөж ч болно. Гэр бүлийнхэн тань танд хамгийн чухал бөгөөд Их Эзэний хувьд ч чухал гэдгийг тэдэнд хэлээрэй.

Хичээл дээр үзсэн зургуудыг тайлбарлахад нь хүүхдэдээ туслаарай. Асуух нь: Хоньчин хониныхоо төлөө юу хийдэг вэ? Давид сайн хоньчин байсан уу? Чи яаж мэдсэн бэ?

Баасан

Магтаал залбирлын үеэр гэр бүлийнхэнтэйгээ хамтраад түүхийг жүжигчилж үзүүлэхэд нь туслаарай. Хүүхэд тань ямар нэгэн тос үнэртэж бас мэдэрч болно. Яагаад Самуел Давидыг тосоор тосолсон тухай ярилцаарай. Залбирлынхаа өмнө Есүсийн тухай дуу дуулаарай.